



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Компанийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Компанийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйл, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 18 дугаар зүйлийн 18.1, 18.5, Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.1.4, 7.7.1, 7.7.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол микрон капитал ББСБ” ХХК-ийг “Некус финанс инвестмент ББСБ” ХХК-д нэгтгэхийг зөвшөөрсүгэй.

2. “Монгол микрон капитал ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

3. Тогтоолын 1-д заасан шийдвэр гарсантай холбогдуулан “Некус финанс инвестмент ББСБ” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 870,000,000 /найман зуун далан сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, хавсралтад заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй.

4. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, зохих бүртгэлийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор ирүүлэхийг “Некус финанс инвестмент ББСБ” ХХК /Б.Ариунаа/-д үүрэг болгосугай.


5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хөрооны
2018 оны 02 дугаар сарын 28-ны
өдрийн 25 тоот тогтоолын хавсралт



“Нексус финанс инвестмент ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн,
хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд оруулах өөрчлөлт

/төгрөгөөр/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс, /Регистрийн дугаар/	Хувьцааны нэрлэсэн үнэ	Хувьцааны эхний үлдэгдэл			Өөрчлөлт		Хувьцааны эцсийн үлдэгдэл		
			Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь	Хувьцааны тоо	Үнийн дүн	Тоо ширхэг	Үнийн дүн	Эзлэх хувь
1	Б.Жаргал /УГ76120207/	1,000	312,500	312,500,000	12.5%	674,000	674,000,000	986,500	986,500,000	29.3%
2	Д.Болормаа /ЧЕ68102501/	1,000	625,000	625,000,000	25.0%	49,000	49,000,000	674,000	674,000,000	20.0%
3	Б.Ариунаа /ЧТ69082961/	1,000	625,000	625,000,000	25.0%	49,000	49,000,000	674,000	674,000,000	20.0%
4	Н.Ариунаа /АЕ74102069/	1,000	0	0	0.0%	674,000	674,000,000	674,000	674,000,000	20.0%
5	Л.Оюун-Эрдэнэ /ХБ69122960/	1,000	312,500	312,500,000	12.5%	49,000	49,000,000	361,500	361,500,000	10.7%
6	Ч.Хишигжаргал /ХД67050961/	1,000	625,000	625,000,000	25.0%	(625,000)	(625,000,000)	0	0	0%
	НИЙТ		2,500,000	2,500,000,000	100%	870,000	870,000,000	3,370,000	3,370,000,000	100%